



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/193

Мандалговь

Хөдөө аж ахуйн ээлжит тооллого  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "л", 5, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 16-ны 74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн тооллогыг 2022 оны 5-7 дугаар сард багтаан зохион байгуулсугай.

2. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан, аймаг, сумдын комиссыг мэргэжил арга зүйгээр ханган тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг комиссын дарга (Б.Энхтуяа)-д үүрэг болгосугай.

4. Тооллогын ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100482

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр  
сарын 29-ний өдрийн 14 дугаар  
захирамжийн хавсралт



ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСЭГ

Комиссын дарга: Б.Энхтуяа (Статистикийн хэлтсийн дарга)

Комиссын орлогч дарга: Б.Мөнхжаргал (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд:

Н.Гантулга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Г.Хишигдаваа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Ж.Батбилэг (Хүнс, Хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны дарга)

Э.Эрдэнэтунгалаг (Хүнс, Хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэл, техник, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Галбадрах (Ойн ангийн дарга)

Х.Дашням (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Т.Бямбасүрэн (Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Н.Давааням (Статистикийн хэлтсийн хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн)